



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 19 өдөр

Дугаар А/277

Сүхбаатар сум

Захирамж хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3, Газрын тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. С.Эрдэнэбаяр нь Орхонтуул сумын Засаг даргаар ажиллаж байх хугацаандаа албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2-т заасны дагуу дуудлага худалдааг зохион байгуулахгүйгээр 2011 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн "Газар эзэмших эрх олгох тухай" А/186 дугаар захирамжаар өөрийн төрсөн эгч С.Эрдэнэчимэгийн төрсөн хүүхэд С.Содномпилийн үүсгэн байгуулсан "HSL" ХХК-д Орхонтуул сумын нутаг дэвсгэр "Хайрханы өвөр" гэх газарт 170901365 нэгж талбарын дугаартай 400 га газрыг 60 жилийн хугацаатайгаар эзэмшүүлж, уг газрыг 2014 оны А/41 дугаартай захирамжаар "HSL" ХХК-иас өөрийн төрсөн эгч С.Эрдэнэчимэгийн төрсөн хүүхэд С.Содномпил, өөрийн төрсөн ах С.Эрдэнэбаттай хамтран үүсгэн байгуулсан "Гэлийн туг" БГБХН-д 200 га, 200 га-аар хуваан эзэмшүүлсэн, мөн 2016 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн "Газар эзэмших эрх олгох тухай" А/105 дугаар захирамжаар "HSL" ХХК-д дахин тариалангийн зориулалтаар Орхонтуул сумын нутаг дэвсгэр "Зөөхий ухаа" гэх газарт 170901365 нэгж талбарын дугаартай 400 га газрыг 60 жилийн хугацаатайгаар тус тус эзэмшүүлж, газар эзэмших эрхийн гэрчилгээг олгож, өөртөө болон бусдад давуу байдал бий болгож, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 6.4, 6.5, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх заалтыг тус тус зөрчсөн нь Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн хяналт шалгалтаар тогтоогдсон тул Орхонтуул сумын Засаг даргын 2011 оны А/186, 2016 оны А/105 дугаар захирамжийг тус тус хүчингүй болгосугай.

2. Цаашид дахин ийм төрлийн зөрчил гаргахгүй ажиллахыг сумдын Засаг дарга нарт анхааруулж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ө.Сувдаа/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ш.ОРГИЛ

